

## **ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:**

### **Доктор Д.Шүрхүү:**

Манай Олон улс судлалын хүрээлэн бол Хятад судлалын том хүрээлэн. Олон хятад судлаачид ажиллаж байсан, энэ уламжлалаараа сонирхолтой, цаг үеэ олсон хурал зохион байгуулж, урьж оролцуулж байгаад талархал илэрхийлье. Энэ илтгэлийг хэлэлцүүлсэн доктор Н.Алтантөгс энэ чиглэлээр нарийвчилсан судалгаа хийж ном хэвлүүлсэн сайн судлаач юм. Цаашдын ажилд нь амжилт хүсье.

Нэгдүгээрт, Монголын XX зууны түүх бол Монгол, Орос, Хятад гурван улсын харилцааны, ялангуяа Монгол дахь Орос, Хятадын ашиг сонирхлын зөрчил тэмцлийн түүх юм. 1952 оны хэлэлцээрийн түүх бол шинэ нөхцөлд Хятад нь Монголд дахин эргэн ирсэн гарааны цэг болно. XX зуунд Монголд Зөвлөлт болон Хятадын нөлөө, худалдаа ээлжилж байсан, үүний нэг мөчлөг нь энэ үед эхэлсэн. XX зууны эхэн үед Монголд Хятадын худалдаа монопол байж, бусад хөгжингүй орнуудын капитал Хятад худалдаачдаар дамжин орж ирж, Монголын уул уурхай, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийг их хэмжээгээр гадагш гаргаж байлаа. Ингээд Октябрийн хувьсгалын дараа Зөвлөлтийн нөлөө орж ирэн, гадаадын болон Хятадын капиталыг шахан гаргаж, Монголд зөвхөн Зөвлөлтийн худалдаа ноёлох болсон. Энэ үед Монгол-Хятадын дипломат харилцаа тасалдсан ч, Монголын удирдагч Х.Чойбалсан Хятадтай холбоо тогтоохыг сонирхож байсан. Анхны Элчин сайд Б.Жаргалсайханд Хятадтай улс төр, худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чухал үүргийг даатгаж, Монгол улс нь 30 гаран жил Зөвлөлтийн дагуул, зөвхөн Зөвлөлт гэсэн зах зээлтэй байсан бол одоо Хятад гэх том зах зээлийг нээх хэрэгтэйг аминчлан захиж байсан. Энэ үе бол Монголд худалдааны шинэ зах зээл, гарц нээгдсэн чухал ач холбогдолтой үе байсан. Маршал Х.Чойбалсан энэ үүднээс “Хятад улс бол зөвхөн Хятад биш, Хятадаар дамжин бусад орнууд руу гарна” гэсэн алсын бодолтой байсан нь өнөөгийн нөхцөлд батлагдаж байна.

Хоёрдугаарт, Худалдааг хийх гол хүндрэл нь зам тээврийн асуудал байв. Тэр үеийн хоёр орны удирдлагууд худалдаа хийх хэрэгцээ их байв ч тээвэрлэлтийн асуудалтай тулсан учир соёлын харилцааг эхлүүлье гэж ярилцаж байжээ. Энэ асуудалтай холбоотой гол нь төмөр замын асуудал байгаа юм. Манай анхны худалдаа, бараа бүтээгдэхүүн Манжуураар дамжин тойрч ирдэг байсан. Энэхүү эдийн засаг, соёлын хэлэлцээрийн үр дүнд хоёр талын болон Монголоор дамжин өнгөрөх тээврийн дэд бүтцийг хөгжүүлснээрээ өндөр ач холбогдолтой. Жинин хүртэл төмөр замыг өргөн царигаар тавьсан. Тэр үед Хятадын тал өргөн царигт таатай хандаагүй ч Зөвлөлтөөс ирэх асар их тусламж, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж, бараа

бүтээгдэхүүнийг төмөр замаар авахаас өөр арга байгаагүй учир арга буюу Зөвлөлтийн тавьсан нөхцөлөөр өргөн цариг тавьж байв.

Гуравдугаарт, Монгол-Хятадын хооронд худалдааг 10 тэрбум долларт хүргэхийн тулд 70 жил болсон, дараагийн 10 тэрбумд хүрэхийн тулд 10 орчим жил л зарцуулах болов уу. Цаашдаа Монгол-Хятадын худалдаа, Монголын уул уурхай, мал аж ахуй зэрэг олон төрлийн бараа бүтээгдэхүүнийг Хятад руу гаргах үүд хаалга өргөжсөөр байна. Шинэ сэргэлтийн бодлого, Боомтын шинэчлэл зэрэг шинэ бодлогуудаас харахад Монгол-Хятадын худалдааны ирээдүй өргөжин тэлнэ. Гэхдээ худалдааны үр ашиг, өр зээл, эдийн засгийн хэт хараат байдал зэрэг асуудлыг анхаарах хэрэгтэй. Зөвхөн Монгол Улсын төв хэсгээр дамжих гарцаас гадна Гашуунсухайт, Бичигтээр дамжуулан зүүн, баруун гэх зэрэг хоёр, гурав дахь гарцууд нээгдэх байх гэж бодож байна.

### **Доктор Б.Отгонсүрэн:**

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгээс зохион байгуулж буй өнөөдрийн хурал Монгол, Хятадын харилцааны чухал баримт бичиг болсон хэлэлцээрийг өнөөдрөөс эргэн харж дүгнэх, тухайн үеийн хоёр орны худалдаа ямар байв, ямар ахиц гарав гэдгийг эргэж харах боломж олголоо гэж үзэж байна. Хурлыг зохион байгуулагчдад талархал илэрхийлье. Хоёр орны харилцаанд газар нутгийн маргаан болон түүхэн улбаатай шийдэгдээгүй асуудал ба зарчмын маргаантай асуудал байхгүй. Харилцаа хамгийн сайн үедээ явж буйг хоёр улсын төрийн тэргүүн нар нотолсон. 2014 онд БНХАУ-ын дарга Ши Жиньпин Монгол Улсад ажиллахдаа хоёр улсын харилцааны тэргүүлэх чиглэлийг “Гурван цогц бодлого” буюу худалдаа, дэд бүтэц, банк санхүү хэмээн тодорхойлсон. Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа түүнийг дагасан зайлшгүй байх тээвэр, дэд бүтэц, төлбөр буюу санхүүгийн асуудлыг багцалж, энэ гурван салбарт тулгуурлан хоёр талын харилцааг хөгжүүлэх ёстой гэж тодорхойлсон байдаг. Хоёр талын хамтын ажиллагаа, хүчин чармайлтаар худалдаа 2021 онд 10.2 тэрбум ам.долларт хүрэв. Монгол Улсын гадаад худалдаа, нийт экспортын 82 хувийг Хятад улс эзэлж байна. 1994 онд хоёр талын худалдаа дөнгөж 33 сая ам.долларын хэмжээтэй байснаас энэхүү 10 тэрбум ам.долларт хүргэхийн тулд багагүй хугацааг зарцуулжээ. Харин худалдааны бүтэц илтгэл дээр гарснаас өөрчлөгдсөн үү? 1950, 1960 онд мал, малын гаралтай түүхий эд, уул уурхайн бүтээгдэхүүн экспортолдог байсан. Одоо бид нэмүү өртөг шингэсэн, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн экспортолж чадаж байна уу гэдэг бол бодох ёстой асуудал мөн.

Хоёр талын худалдаа ерөнхийдөө түүхий эдийг өдөр тутмын өргөн хэрэглээний бэлэн бараа бүтээгдэхүүнээр арилжих таваарын арилжааны хэлбэрээсээ төдийлөн ахиагүй нь харагдаж байна. Хоёр тал дээд хэмжээний уулзалтаараа «Бүс ба зам», «Талын зам» гэх зэргийг дурдаж хоёр улсын

хөгжлийн бодлогуудыг уялдуулъя гэдэг дээр санал нэгддэг. Гэхдээ бодлогыг уялдуулна гэдэг аялдан дагалдана гэсэн үг биш. Бид Хятадын хөгжлийн бодлогыг газарзүйн бүс нутгаар хуваагаад, ямар салбарыг аль бүс нутагт хэрхэн хөгжүүлж байна, тэр нь Монгол Улсын эдийн засгийн багтаамж болон эдийн засгийн хүчин чадал, бүтцийн онцлогтой хэрхэн уялдах, ямар боломж байгааг судалж, угтаж өөрсдийнхөө бодлогыг боловсруулах хэрэгтэй. Илтгэгчийн энэ удаагийн илтгэлээс олон сайхан сонирхолтой зүйлийг олж сонслоо, баярлалаа.

### **Доктор Т.Чулуун-Эрдэнэ:**

Монгол-Хятадын харилцааны үндэс суурь болсон энэ хэлэлцээрийн тухай тусгайлан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, урьж оролцуулж байгаад баярлалаа. Монгол-Хятад үндэстний харилцаа олон мянган жилийн түүхтэй ч орчин үеийн харилцаа 1949 онд БНХАУ байгуулагдсанаар эхэлсэн гэж үзэж болдог. 1950-иад оны үе бол хоёр орны улс төр, үзэл суртал, эдийн засаг, аюулгүй байдлын бодит хэрэгцээ шаардлагад тулгуурласан найрсаг харилцаа хөгжиж байсан үе болно. Илтгэгч 1953-1955 оныг хоёр орны эдийн засгийн харилцааны идэвхжилийн үе хэмээн томъёолж, энэ үед Монгол-Хятадын харилцаа эрс сайжирч, эдийн засгийн дэвшилд хүрсэн нь Хятад болон Зөвлөлтийн харилцаа ба тэдгээрийн гадаад бодлогод суурилсан гэж онцолсон байна. 1953 онд И.Сталин нас барж Н.Хрущёв ЗХУКН-ын ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдсон билээ. Үүнээс улбаалаад Хятад улс тухайн үеийн Зөвлөлттэй харилцах харилцаандаа маш их анхаарч эхэлсэн. Мөн Зөвлөлтөөс маш их бүтээн байгуулалтыг Хятадад хийхээр төлөвлөсөн. Хятадын хувьд 1950-аад онд хөрш зэргэлдээ улс орнуудтайгаа дипломат харилцаа тогтоож тусгаар тогтнолоо баталгаажуулж чадсан байдаг. Тухайн үеийн Ерөнхий сайд, Гадаад явдлын сайд Жоу Энълай энх тайвнаар зэрэгцэн орших таван зарчмыг дэвшүүлсэн юуны өмнө тухайн үеийн социалист улс орнуудын дэмжлэгийг хүлээж байсан ба ЗХУ, БНХАУ-ын хооронд албан ёсны харилцаа тогтсон нь эргээд Монгол, Хятадын харилцаанд эергээр нөлөөлсөн юм. Илтгэлийг сонсож байхад Ерөнхий сайд Ю.Цэдэнбал Монгол-Хятадын харилцаанд яг ямар үүрэг гүйцэтгэсэн юм бол, ямар нөлөөтэй түүхэн бие хүн байв гэдэг асуулт ургаж, миний сонирхлыг ихээр татлаа. Мөн илтгэлд сонирхолтой тоо баримтуудыг оруулжээ. Жишээ нь 1952 онд БНХАУ нь БНМАУ-д өртэй байв, 15000 адууг Зөвлөлтийн авдгаас ч илүү өндөр үнээр манайхаас худалдан авч байсан гэсэн сонирхолтой баримтуудыг дурдсан байна. Баярлалаа.